



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн
Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайлан



**Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигтэй
нийцүүлэн төлөвлөсөн 4 зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл хийгээгүй
1,690.0 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг хуулиар баталж хэрэгжүүлсэн байна.**

“Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитад Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд санхүүжүүлэхээр баталсан 95 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн Засаг дарга болон түүний харьяа байгууллагууд, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч зарим аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулан хийж гүйцэтгэлээ.

Увс аймагт 2022 оны төсвийн тухай хуулиар 143.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 74 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 2022 онд олгох санхүүжилт нь 28.0 тэрбум төгрөг байна. Аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 8/01 дүгээр тогтоолоор аймгийн хөрөнгө оруулалтаар 1.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээ, 1.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 их засварын төсөл, арга хэмжээг тус тус баталсан байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар Увс аймагт хэрэгжүүлэхээр батлагдсан 74 төсөл, арга хэмжээ нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжиж боломжтой байна. Дээрх төсөл, арга хэмжээг салбараар авч үзвэл дараах байдалтай байна.

№	Салбар	Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл арга хэмжээний тоо	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтын тоо
	Боловсрол		
	Эрүүл мэнд		
	Эдийн засаг		
	Байгаль орчин		
	Дэд бүтэц		
	Бусад		
	Нийт		

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 32 төсөл, арга хэмжээнээс орон нутагт эрх шилжиж ирсэн 10 төсөл, арга хэмжээ байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар Увс аймагт хэрэгжүүлэхээр батлагдсан 74 төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн уялдааг хангасан, хүрч болохуйц эерэг өөрчлөлтийг бий болгож байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2022 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх эрх шилжиж ирсэн 10 төсөл, арга хэмжээнээс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно” гэж заасны дагуу тайлан оны 1 төсөл, арга хэмжээг 2 багц, өмнөх оноос шилжсэн 1 төсөл, арга хэмжээг 12 багц болгон, нийт 23 худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Орон нутгийн өмчийн газар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт 2022 онд хэрэгжих эрх шилжиж ирсэн 10 төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, өмнөх оноос шилжсэн 1 төсөл арга хэмжээнд нийт 23 тендер худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулсан байна.

Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд батлагдсан 74 төсөл, арга хэмжээнээс 56 барилга байгууламжийн ажлыг хэрэгжүүлэхээр тусган баталсан байна. Үүнээс 31 барилга байгууламж нь эрх шилжээгүй, 25 нь эрх шилжиж ирсэн бөгөөд 2022 онд дуусахаар төлөвлөсөн 31 барилга байгууламж, он дамжин хэрэгжихээр төлөвлөсөн 25 барилга байгууламж байна.

2022 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн 31 барилга байгууламжаас 22 барилга байгууламжийг улсын комисс байнгын ашиглалтад хүлээн авсан байна.

Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд нийт 9 их засварын ажлыг хэрэгжүүлэхээр тусган баталсан байна. Үүнээс 1 ажил нь эрх шилжээгүй, 8 ажил нь эрх шилжиж ирсэн байна.

Түүнчлэн 8 их засварын ажил 2022 онд, 1 их засварын ажил он дамжин хэрэгжиж 2023 онд дуусахаар байна.

Дээрх их засварын ажлуудаас 7 ажил бүрэн хэрэгжсэн. Наадмын талбайн тохижилт /Увс, Улаангом сум/ 2 багцад задарсан байна. Үүнээс: Багц 2 наадмын талбайн тохижилтын ажлыг улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

Харин Багц 1 Хөл бөмбөгийн талбайг тойруулан гүйлтийн зам хийх ажилд 2022 онд 221.0 сая төгрөг төсөвлөсөн боловч ажил хийгдээгүй тул санхүүжилтийг олгоогүй байна. Тус ажлыг гүйцэтгэж байсан компанийн захирал нас барснаас шалтгаалж үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн цахилгаан шат /Увс, Улаангом сум/ нийт 228.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй их засварын ажил гүйцэтгэгчээс шалтгаалан ашиглалтад ороогүй ба 2022 онд олгохоор төлөвлөсөн 180.7 сая төгрөгөөс 136.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх 5 төсөл, арга хэмжээ байна.

Дээрх техник, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлуудаас 3 ажил бүрэн хэрэгжсэн, Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Увс/ 11 багцад задарсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн технологийн кабинетын тоног төхөөрөмж /Увс, Тэс, Баруунтуруун, Улаангом сум/ 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерт Хул консалтинг ХХК шалгарч 148.5 сая төгрөгөөр 2022 оны 09 сарын 30-ны дотор нийлүүлэхээр гэрээ байгуулсан байна. Тоног төхөөрөмжийг хугацаандаа нийлүүлж чадаагүй тул тус компаниас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн гэрээг 2022 оны 12 дугаар сарын 30 хүртэл сунгасан байна. Гэвч тус компани 75.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн тул хэсэгчлэн хүлээн авч 75.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн "ТЭЗҮ" ангилалд тусгагдсан 4 төсөл, арга хэмжээнээс 3 төсөл арга хэмжээ нь орон нутагт эрх шилжиж ирээгүй байна.

Баруун 4 замын уулзварын өргөтгөл, 3 дугаар 10 жилийн тойрог хүртэлх авто замын шинэчлэлийн зураг төсөв /Увс, Улаангом сум/ он дамжин хэрэгжиж 2023 онд дуусахаар төлөвлөгдсөн байна. Тус зураг төсвийн гүйцэтгэгчээр Ихэрмөнх ХХК шалгарч 74.2 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулж 10.0 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн эрх шилжиж ирсэн 38 төсөл, арга хэмжээнээс 23 төсөл, арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авч санхүүжилтийг олгосон байна.

Харин дутуу хэрэгжсэн 8 төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэлд ногдох санхүүжилтийг олгож 2022 онд ямар нэгэн ажил хийгдээгүй болон гүйцэтгэл ирүүлээгүй 7 төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгоогүй байна.

Хууль дүрэмд заасны дагуу 28 барилга байгууламж хүлээн авахдаа үүрэг даалгавар өгснөөс 21 барилга байгууламжид өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцсон ба 7 барилга байгууламжид өгсөн үүрэг даалгаврын биелэлт улирлын нөхцөл байдлаас шалтгаалан хангагдаагүй байна.

Гүйцэтгэлийн аудитаар 7 зөвлөмж, 1 төлбөрийн акт тогтоолоо. Мөн Үндэсний аудитын газарт 1 санал хүргүүлсэн болно. Аудитаар илэрсэн зөрчлийг дараах байдлаар шийдвэрлэлээ.

Аудитаар тогтоосон төлбөрийн акт:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 6.4.8 дахь заалтад “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчин Тариаланчдыг ургамал хамгааллын бодис, бордоогоор хангахад дэмжлэг үзүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд 7 суманд зээлээр олгосон ургамал хамгааллын бодис, бордооны үнийг төсөвт төвлөрүүлээгүй, авлагаар тусгаагүйд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

№	Сумын нэр	Төвлөрүүлэх мөнгө /төгрөг/
1	Баруунтуруун	2912000
2	Давст	322500
3	Тариалан	1838300
4	Түргэн	337000
5	Өндөрхангай	778000
6	Өмнөговь	450000
7	Сагил	454000
Нийт		7091500

Аудитаар өгсөн зөвлөмжүүд:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “Тендерт оролцогчийн техникийн чадавх, туршлагыг ажил, бараа, үйлчилгээний агуулга, онцлог, тоо хэмжээг харгалзан дараах үзүүлэлтийн аль нэгийг үндэслэн тогтооно”, 16.1.2 дахь заалтад “сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт” гэж заасны дагуу тендерийн бичиг баримтад хуулийн шаардлагыг тавьсан ч үнэлгээний хороо гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа зарим тендерт тус шаардлагыг харгалзан үзээгүй зөрчилд тендерийн бичиг баримтад заасан шаардлага хангаагүй тохиолдолд дахин тендер зарлаж байхыг зөвлөмж өгсөн.

Ерөнхий боловсролын сургуулийн технологийн кабинетын тоног төхөөрөмж /Увс, Тэс, Баруунтуруун, Улаангом сум/ 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерт Хул консалтинг ХХК шалгарч 148.5 сая төгрөгөөр 2022 оны 09 сарын 30-ны дотор нийлүүлэхээр гэрээ байгуулсан байна. Тоног төхөөрөмжийг хугацаандаа нийлүүлж чадаагүй тул тус компаниас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн гэрээг 2022 оны 12 дугаар сарын 30 хүртэл сунгасан байна. Гэвч тус компани 75.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлсэн тул хэсэгчлэн хүлээн авч 75.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Нийлүүлэгдээгүй үлдсэн тоног төхөөрөмжийг гэрээний дагуу гүйцэтгэгчээс бүрэн хүлээн авах, ирсэн тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөхийг зөвлөмж болгов.

Шинэ хөдөө төслийн хүрээнд нийлүүлэгдсэн 29 хүлэмжийг иргэдэд гэрээгээр үнэ төлбөргүй ашиглуулж байна. Цаашид аймгийн ИТХ-ын 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 9/7 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 1.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3,4,5-д зааснаас бусад орон нутгийн өмчийн бүх төрлийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх эд хөрөнгийг түрээслүүлж болно” гэж заасны дагуу иргэдэд гэрээгээр ашиглуулж байгаа хүлэмжийг түрээсээр ашиглуулах асуудлыг судалж шийдвэрлэхийг зөвлөмж болгосон.

Хууль дүрэмд заасны дагуу 28 барилга байгууламж хүлээн авахдаа үүрэг даалгавар өгснөөс 21 барилга байгууламжид өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцсон ба 7 барилга байгууламжид өгсөн үүрэг даалгаврын биелэлт улирлын нөхцөл байдлаас шалтгаалан хангагдаагүйд биелэлтийг хангуулж хэрэгжилтийг тооцох зөвлөмж өгсөн.

Байнгын ашиглалтад орсон 31 барилга байгууламжийг Төрийн өмчийн хорооны шийдвэр ирээгүйгээс данс бүртгэлд тусгаагүйг холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлүүлэхийг зөвлөмж өгсөн.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалтад “Хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг ойлгоно” гэж заасныг зөрчиж урсгал зардлын шинжтэй 3 төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр баталсан байна. Үүнд:

- Бүх нийтийн эрүүл мэнд, ахуйн үйлчилгээний чанартай үйлчилгээг хөдөөгийн иргэдэд хүргэх Баг-93 зорилтот арга хэмжээг зохион байгуулах
- Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл
- Тариаланчдыг ургамал хамгааллын бодис, бордоогоор хангахад дэмжлэг

Цаашид хөрөнгө оруулалтын шинж чанаргүй төсөл, арга хэмжээг төлөвлөн батлахгүй байхыг зөвлөмж болгов.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 21 төсөл, арга хэмжээнээс 17 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна. Харин гэрээний хугацаанд хэрэгжээгүй 1, хэрэгжиж дуусаагүй 3 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- Цэвэр усны автомашин худалдан авах /Өлгий сум/ 54.9 сая хэрэгжээгүй
- Орлогын голд модон гүүрний засвар шинэчлэл хийх 207.6 сая хэрэгжиж дуусаагүй
- Галданбошигт хүндэтгэлийн өргөөний засвар хийх 40.0 сая хэрэгжиж дуусаагүй
- Наадмын талбайн ногоон байгууламж хийх 100.0 сая хэрэгжиж дуусаагүй

Цаашид гэрээний хугацаанд хийж дуусгаагүй төсөл, арга хэмжээний ажлыг гүйцэтгэгч компаниар хийлгүүлэхийг зөвлөмж болгов.

ҮАГ-т хүргүүлсэн санал:

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасан байхад хуульд заасан шаардлага хангаагүй 8 төсөл арга хэмжээг 2022 онд эхлүүлэхээр баталсан байна.

Түүнчлэн 4 барилга байгууламж, 1 их засварын ажлын зураг төсөв Монгол улсын 2021 оны төсвийн тухай хууль батлагдсаны дараа боловсруулагдсан байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Засгийн газар барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 32.1.11 дэх заалтад “Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Үүнээс шалтгаалан тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсөвт өртөг нэмэгдэх, зориулалт өөрчлөгдөх зэрэг сөрөг үр дагаврууд гарсан байна. Тухайлбал:

- Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд 300.0 сая төгрөгөөр 2022-2023 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан Хангилцагийн голын модон гүүр /Увс, Цагаанхайрхан сум/ зураг төсвийг боловсруулж магадлалаар ороход төсөвт өртөг нь 576.5 сая төгрөг болж 276.5 сая төгрөгөөр нэмэгдсэнийг 2023 оны төсвийн тухай хуульд нэмж тусгасан.
- Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд 300.0 сая төгрөгөөр 2022-2023 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан Баруун голын бетон гүүр, 10 у/м /Увс, Өлгий сум/ ТЭЗҮ-г боловсруулахад гүүр тавих боломжгүй тул 2023 оны төсвийн тухай хуульд баруун гол дээр баригдах замын байгууламж болгон өөрчилсөн. Түүнчлэн төсөвт өртөг нь 288.9 сая төгрөг болж 11.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Цаашид Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ТЭЗҮ, зураг төсөв хийгдсэн ажлыг төлөвлөн батлуулж байхыг Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлээ.